



МУИС-ЭЗХ



ӨМИС-МУСХ

**Шинэчлэлээс шинэчлэл рүү: ӨМӨЗО болон
Гүйжөү мужийн ядуурлаас ангижруулах
бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө**

Судалгааны багийн ахлагч: Х.Цэвэлмаа

МУИС-ЭЗХ-гийн захирал

Email: tsevelmaa@num.edu.mn

Улаанбаатар хот

2019 он

АГУУЛГА

Хураангуй	3
Оршил	4
БНХАУ-ын Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгүүд 1978-2017	5
ӨМӨЗО болон Гүйжөү мужийн хоёр байршилд хэрэгжиж буй ядуурлаас ангижруулах бодлого ба хэрэгжүүлсэн үйл ажиллагаа.....	9
БНХАУ-ын ӨМӨЗО ба Гүйжөү мужийн ядуурлаас ангижруулах бодлогын хэрэгжилтийн өнөөгийн байдлын харьцуулалт	10
ӨМӨЗО болон Гүйжөү мужийн хоёр байршилд ядуурлаас ангижруулах бодлогын хэрэгжилтийн үр дүн.....	11
Ядуурлаас ангижруулах бодлогын институцийн тогтолцоо	12
Ядуурлаас ангижруулах бодлогын хэрэгжилтийн үр нөлөө, суралцах туршлагаас	13
Ашигласан материал.....	14

Хураангуй

МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэн, ӨМӨЗО-ы Монгол Улсыг судлах хүрээлэн, МҮОНТ болон ӨМӨЗО-ы Одон телевизийн хамтарсан судалгааны баг 2019 оны 6 дугаар сарын 17-28-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган болон Тонгляо аймаг, БНХАУ-ын өмнөд хэсгийн Гүйжөү мужийн Аншун болон Хуйшуй шянь гэх зэрэг газруудад ажилласан.

Судалгааны баг нь БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган болон Тонгляо аймаг, БНХАУ-ын өмнөд хэсгийн Гүйжөү мужийн Аншун болон Хуйшуй шянийн ядуурлаас ангижруулахтай холбоотойгоор авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, туршлагыг судалсан.

НҮБ нь 1990 онд Хүний хөгжлийн илтгэлийг анхлан гаргаж, 2000 онд дэлхий дахинд Мянганы хөгжлийн тунхаг, 2001 онд Мянганы хөгжлийн зорилго, 2015 онд Тогтвортой хөгжлийн зорилгыг тус тус санал болгосноор дэлхийн улс орнуудын засгийн газрын тэргүүн зорилт нь ядуурлыг арилгах бодлогоо илүү нарийвчлан томъёолох болсон. БНХАУ-ын ядуурлыг устгах, ядуурлыг бууруулах, ядуурлаас ангижруулах бодлогын залгамж холбоо тасралтгүй 40 гаруй жил үргэлжилж байна.

Дэлхийн улс орнуудын ядуурлын шинж байдал, ядууралтай холбоотой асуудал, ядуурлын шалтгаан олон янз байгаа ч аж үйлдвэржилтийн нөлөө, засаглалын тууштай байдлын үр дүнд ядуурлыг бууруулах шийдлийг олсоор байна. Үүний нэг жишээ бол БНХАУ-ын Коммунист нам болон Засгийн газар засаглал ба хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой хариуцлагад илүү төвлөрснөөр ядуу бүс, ядуу өрхүүдийг ядуурлаас ангижруулах бодлогоо тууштай явуулан намын манлайлал нь “зөв цагт зөв мэдээлэл”, “зөв цагт зөв үйлдэл”-ээр илэрч байна.

БНХАУ-ын ус хамгаалал, төмөр зам, хурдны зам, усан зам, агаарын зам, нефтийн ба байгалийн хийн хоолой, эрчим хүчний шугамууд, мэдээлэл ба логистикийг цогцоор нь авч үзэх дэд бүтцийн сүлжээ нь ус ба дэд бүтцээс алслагдмал бүс нутгийг ядуурлаас ангижруулахад нэн чухал нөлөөтэй байна. Намын манлайлал дор аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулж, дэлгэрүүлэх, сурталчилах, мэдээлэх гэх зэргээр Хятадын онцлогтой соён гэгээрүүлэх арга хэмжээ нь ядуу бүс нутгийн ядуу өрхүүдийг ядуурлаас ангижруулахад чухал ач холбогдолтой. Ийнхүү нийгэм, эдийн засаг, соёл, улс төр, байгаль орчин гэсэн таван асуудлыг багцлан шийдвэрлэхээр “Хятад мөрөөдлөө Хятадын хүн амын мөрөөдөл” болгон хувиргасан нь ядуурлаас ангижруулах бодлогыг хэрэгжүүлэх суурь хөрс болжээ. Энэхүү ажлын хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган болон Тонгляо аймаг, БНХАУ-ын өмнөд хэсгийн Гүйжөү мужийн Аншун болон Хуйшуй шяньд ядуурлаас ангижруулахаар явуулж буй үйл ажиллагааг бодлого ба хэрэгжилтэй холбон авч үзлээ.

Оршил

БНХАУ-ын ядуурлыг бууруулах стратеги нь биет болон хүний нөөцийг ядуурал ихтэй бүс нутгийн ядуучууд руу төвлөрүүлж, улс орныхоо хөгжлийн чанарыг ахиулахад чиглүүлж байна. Алслагдмал бүс нутгийг сонгон ядуурлаас ангижруулах төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа нь дэд бүтцийн хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй ба аж үйлдвэрийн нийлүүлэлтийн сүлжээг өргөжүүлэхийн зэрэгцээ хөдөөгийн хүн амын боловсрол, эрүүл мэнд, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэж байгааг судалгааны үр дүнгүүдээс харж болно.

БНХАУ-ын аж үйлдвэр-үйлчилгээний сүүлийн 15 жилийн шинэчлэл нь хөдөө аж ахуйд явуулсан сүүлийн 30 жилийн шинэчлэл дээр суурилж байгаа юм. БНХАУ-ын газарзүй, орон зайн мэдээллийн систем нь ядуу ба ядуу бүс бүс нутгийг ялган харах боломжоор хангаж байдаг. Энэ нь ядуурлыг ул үндэстэй судлах, ядуурлын шинж байдлыг тодорхойлох, судалгаа шинжилгээний үндсэн дээр үндсэн даалгавар болон хэрэгжүүлэх гол алхмуудыг шийдвэрлэхэд дэмжлэг болж байна.

БНХАУ-ын нийлүүлэлтийн талын бүтцийн шинэчлэл бол эдийн засгийн бүтцийг тогтвортойгоор сайжруулахад нөлөөлж, шинэ салбаруудыг, тухайлбал, дижитал эдийн засаг, өндөр хурдны төмөр замын барилга, хурдны зам, гүүр, усан боомт, нисэх буудал болон бусад дэд бүтцийн салбарын хөгжлийг хурдасгасаар байна. ХАА-н шинэчлэл мөн тогтвортой хийгдэж, жилийн үйлдвэрлэлийн хэмжээ 600 сая метрик тоннд хүрсэн. Хотжилтын түвшин ахиж, жилд дунджаар 1.2 хувиар нэмэгдэж байгаа бөгөөд 80 саяас илүү хүн хөдөөгөөс хот руу шилжиж, байнгын хотын иргэншилтэй болж байна.

Бүс нутгийн хөгжил харьцангуй тэнцвэржиж, Бүс ба зам санаачилга, Бээжин-Тяньжин-Хэбэйг уялдуулсан бүс, Янцзы эдийн засгийн бүс гэх зэрэг нь үүний тод жишээ болно.

14 онцлогтой Хятадын социализм¹ нь шинэ зууны зорилго, зорилт, төлөвлөгөө, стратегийг дотоод болон гадаадад таниулж, хөгжлийн чиглэл, загвар, хөтлөх хүч, стратегийн алхам, улс төрийн баталгааг чухалжилж байна. Энэ хүрээнд онолын судалгаа хийж, эдийн засгийн бодлого, улс төрийн үйл хэрэг, хууль дээдлэх ёс, шинжлэх ухаан ба технологи, соёл, боловсрол, хүмүүсийн сайн сайхан байдал, угсаатан болон шашин, нийгмийн хөгжил, байгаль орчны хамгаалал, үндэсний аюулгүй байдал ба зэвсэгт хүчин, “нэг улс ба хоёр систем”, үндэсний нэгдмэл байдал, гадаад хэрэг, намын чадавхи гэх зэрэгт бодлогын чиглэмж гарган хөгжлийн шинэ туршлагыг бэхжүүлэн хөгжүүлэн гэж заасан. БНХАУ-ын Коммунист нам болон Засгийн газар дөрвөн хэсэгтэй² хөгжлийн стратегийг баримталж,

1978 оноос хойш Хятад улс засгийн газрын шинэчлэлийн бодлого болон хурдтай эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр өргөн хүрээтэй байсан ядуурлыг огцом бууруулах болсон. Албан ёсны ядуурлын шугамын дагуу 1981 онд 200 сая байсан ядуу хүмүүсийн тоо 2000

¹ Secure a Decisive Victory in Building a Moderately Prosperous Society in All Respects and Strive for the Great Success of Socialism with Chinese Characteristics for a New Era Delivered at the 19th National Congress of the Communist Party of China October 18, 2017 Xi Jinping

² Хөгжлийн зам, онол, систем, Хятадын онцлогтой социализмын соёлыг онцолж байна.

онд 28 сая болж буурчээ. Дэлхийн банкны өдөрт 1\$ орлогын хэмжүүрийг ашиглавал ядуу хүмүүсийн тоо дээрх хугацаанд 490 саяас 88 сая болж, ядуурлын хүрээ 1981 онд 49 хувь байсан бол 2002 онд 6.9 хувь болсон. 1979-2003 оны хооронд Хятад улсын бодит ДНБ жилд дунджаар 9.4 өссөн нь өргөн хүрээтэй ядуурлыг бууруулахад хүчтэй нөлөөлсөн. Төвлөрсөн төлөвлөлтөөс зах зээл рүү, ХАА-гаас аж үйлдвэр ба үйлчилгээ рүү шилжиж, олон улсын худалдаа ба мэдлэг шилжих үйл явцыг нээлттэй болгосон. Ийнхүү 1981 онд хүн амын 85 хувь нь өдрийн 1.25 ам.доллараас бага орлоготой байсан нь 2008 он гэхэд 13.1 хувь болтол буурч, ойролцоогоор 700 сая хүнийг ядуурлаас гаргасан нь ядуурлаас ангижруулах бодлогын үр нөлөө юм.³ 2017 оны байдлаар БНХАУ-ын хувьд ядуурлын үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь 3.1 байгаа нь бүс нутгийнхаа бусад улс орнуудтай харьцуулахад үнэхээр бага үзүүлэлт юм.

Олон улсын болон дотоодын түвшинд хийгдсэн нарийвчилсан шинжилгээнээс харахад Хятадын улсын хөгжлийн замд хоёр зууны зорилго (1920-2020, 1949-2049) нь Хятад хүний мөрөөдөл болж, дундаж давхаргыг нийгмийн бүхий л түвшинд цогцлоох (Дэн Сяопиний онол, 1979) стратеги хэвээр хадгалагдаж байгаагаас гадна 2020-2050 он хүртэлх дараагийн 30 жилд хоёр үе шаттайгаар хөгжлийн бодлого төлөвлөлтийг тодорхойлоод байгаа юм. 2020-2030 онд социализмыг бодит утгаар хөгжүүлэх хүнд сорилттой тулгарч байгаа хэдий ч эдийн засаг-технологийн давуу талаа илүү бэхжүүлэх хандлагатай байна. Хятад улс инновацийн хувьд глобал лидер байх алсын хараатай. Хүний эрхийг дээдэлж, тэнцвэрт байдлыг хадгалах, нийгмийн соёлыг мэдэгдэхүйц бэхжүүлэх, Хятад соёлын уян чадамжийг илүү хүчтэй болгох, хүмүүсийн амьдралын түвшинг ахиулж, дундаж орлоготой давхаргын эзлэх хувийн жинг эрс өсгөх, хот-хөдөөгийн ялгааг багасгаж, нийгмийн үйлчилгээг жигд хүртээх, хөгжил цэцэглэлтийн үр өгөөжийг бүгд хүртэх гэсэн зорилтыг хэрэгжүүлэхээр заасан. Энэхүү 25 жилийн зорилго бүхэлдээ “Үзэмжит Хятад улс”-ыг бренд болгох юм.

Хөгжлийн дараагийн шатны хоёр дахь үе 2035 оноос эхлэх бөгөөд орчин үеийн социалист улс байх, өөрөөр хэлбэл, шаргуу ажилласны үр дүнд Хятад улс хөгжиж цэцэглэсэн, хүчтэй, ардчилалтай, соёлын түвшингээ ахиулсан, эв найртай, үзэмжит улс болно гэж тодорхойлсон. Үүний үр дүнд эд материал, улс төр, соёл, угсаатан, экологийн ахиц дэвшил нь түвшин бүртээ өндөр хэмжээнд хүрч, үндэсний чадавхи болон олон улсын нөлөөгөөрөө глобал лидер болно гэжээ.

БНХАУ-ын Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгүүд 1978-2017

БНХАУ-ын Коммунист нам болон Засгийн газрын 1970-аад хойш хэрэгжүүлж буй шинэчлэлийн бодлого, тэр дотроос ядуурлыг бууруулах бодлого таван үе шаттай явагджээ. 1978-1985 онд ХАА-н хөгжлөөрх үндэсний хөдөөгийн шинэчлэл ба ядуурлыг бууруулах бодлого, 1986-1993 онд Үндэсний ядуурлыг бууруулах болон хөгжлийн хөтөлбөр, 1994-2000 онд 8-7 Ядуурлыг бууруулах төлөвлөгөө, 2001-2010 онд Хөдөөгийн ядуурлыг устгах болон хөгжлийн хөтөлбөр, 2011-2020 онд Нарийн тогтоож ядуурлыг устгах стратегийг тус тус хэрэгжүүлсэн бөгөөд хэрэгжүүлж байна.

³ Human development report 2009 – “Population living below \$2 a day”

Ерөнхийдөө хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тэлж, хөдөөгийн институцийн болон бодлогын шинэчлэлийг дэмжих замаар хөдөөгийн эдийн засгийн өсөлтийг хангахад голлон анхаарсан. 1980-аад оноос хойш институцийн болон бодлогын шинэчлэлийг өргөн хүрээтэй явуулах болсон. Гол нь өрхийн хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлж, хөдөө орон нутагт өрхүүд гэрээт газар дээрээ юуг, хэрхэн үйлдвэрлэхээ шийдсэн нь өөрчлөлт шинэчлэлтийн суурь болсон. Засгийн газрын ХАА-н бүтээгдэхүүнийг худалдан авах үнэ өсөж, хөдөөгийн зах зээлийг нээлттэй болгон хөдөөгийн үйлдвэрлэгчдийг илүү дэмжсэн. ХАА-н үйлдвэрлэлийн шинэчлэлийн нөлөөгөөр ядуурал мэдэгдэхүйц хэмжээгээр буурчээ.

1980-аад оны дунд үеэс зорилтот ядуурлыг устгах интервенци явуулсан. 1986 онд Ядуурлыг бууруулах болон хөгжлийн чиглүүлэх группыг Төрийн зөвлөлийн дэргэд байгуулсан байдаг. Ядуурлыг бууруулах болон хөгжлийн чиглүүлэх группын ажлын хэсэг ядуу бүс нутгийн бүх түвшний засаг захиргааны нэгжүүдэд байгуулагдсан. Нийт 332 дүүрэг, суманд гол хэрэгжүүлсэн арга хэмжээ бол нэгдүгээрт, хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр; хоёрдугаарт, ажлын байртай болгож хүнсээр хангах хөтөлбөр; гуравдугаарт, төсөв хүндрэлтэй бүс нутгийн хөгжлийн тусламж байсан. Зээлийн хөтөлбөрт ядуу дүүрэг, сумдын өрхүүд болон аж ахуйн нэгжүүд хамрагдаж, хөнгөлөлттэй зээлээр хангагдсан. Ажлын байртай болгож хүнсээр хангах хөтөлбөр нь хөдөөгийн илүүдэл хөдөлмөрийг дэд бүтцийг хөгжүүлэхэд, тухайлбал, зам, усжуулалт, ундны усны худаг гаргахад ашигласан. Харин засгийн газрын тусламжийг ядуу бүс нутагт технологи дамжуулах, боловсрол болон эрүүл мэндийг сайжруулахад зарцуулсан.

1994 онд батлагдсан 8-7 Ядуурлыг бууруулах төлөвлөгөө нь: нэгдүгээрт, өрхийн нэг хүнд ногдох цэвэр орлогыг өсгөх; хоёрдугаарт, ядуу өрхүүдийн газар ашиглалтыг сайжруулж, ургацыг нэмэгдүүлэх, жимс жимсгэнэ болон мал аж ахуй эрхлэх, фирмийн бус ажил эрхлэлтийн боломжийг ихэсгэх гэх зэрэгт оролцох; гуравдугаарт, илүү ядуу дүүрэг, сумдыг зам болон цахилгаанаар хангах, ядуу өрхийн ундны усны хэрэглээг сайжруулах; дөрөвдүгээрт, анхан шатны болон бүрэн дунд боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг үйлчилгээг сайжруулах; тавдугаарт, далайн эргийн тосгодыг ядуу дүүрэги жагсаалтаас хасаж, нөхцөл байдлыг сайжруулах; зургаадугаарт, дотоод болон гадаадын бүх оролцогч талуудыг ядуурлыг бууруулахад татан оролцуулах зорилготой байсан. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд ядуурлыг бууруулах ажлын үр ашиг, үр өгөөжийг дээшлүүлэхэд голлон анхаарч, орон нутгийн бүх түвшний удирдлагуудын хариуцлагад төвлөрөх талаар Коммунист нам ажилласан. 1986 онд баталсан гурван хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлжээ. Үүнээс гадна засгийн газрын ядуурлыг устгахад чиглэсэн жилийн санхүүжилт бодит дүнгээр жил тутам 50 хувиар нэмэгдсэн. Хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг төрийн өмчит банк хэрэгжүүлж, санхүүжилтийг их хэмжээгээр өсгөсөн байдаг. Эдгээрийн үр дүнд ядуу бүс нутгийн сангийн хуваарилалт сайжирч, орлого нэмэгдсэн.

2001 оноос эхлэн ядуурлыг бууруулах бодлогод өөрчлөлт орсон. Ядуурлыг бууруулах бодлого зорилтот дүүрэг, сумаас зорилтот гацаа, баг руу шилжсэн. Хятад улс 592 ядуу дүүрэг, сумдын нэрсийг шинэчилсэн. Эдгээрийн дотор болон эдгээрээс гадна байх 150000 ядуу тосгон, гацааг тодорхойлж, ядуурлыг устгах гол зорилт болгон зарласан. Ядуу байсан дүүрэг, сумд нь ХАА-н татварын шинэчлэл, дэд бүтцийн хувьд ядуурлын сангаас хуваарилах санхүүжилт, нийгмийн хөгжил гэх зэргээс үр өгөөж хүртсэн төдийгүй ядуу тосгон, гацааны ядуурлыг устгахын тулд тосгоны иж бүрэн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хөдөлмөрийг сурган шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, бүс


нутгийн хөгжлийг дэмжих хийгээд хөдөөгийн ядуурлыг бууруулахаар ядуу дүүрэг, сумдад салбаруудыг хөгжүүлэх чиглэлийг төлөвлөсөн. 150000 ядуу тосгон, гацаа нь өөрсдийнхөө хэрэгжүүлэх төслүүдийг гаргаж, нарийвчилсан төсөв болон санхүүжилтийн хуваарилалт хийхдээ өөр зөвлөхүүд болон орон нутгийн засаг захиргаанаас дэмжлэг авсан. Орон нутгийн засаг захиргааны ядуурлаас ангижруулах талаарх чиг үүрэг их тодорхой болжээ. Энд нэг шаардлага бол багадаа 500 ядуу өрх хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгжээс үр өгөөж хүртэх юм. Энэ мэтчилэн арга хэмжээ авч хэрэгжүүлснээр 1978 оны ядуурлын шугамаар хэмжихэд хөдөөгийн ядуу хүн амын тоо 2000 онд 32 сая байснаа 2007 онд 15 сая болж буурсан.

2011 онд шинэ стратеги тодорхойлогдсоноор ядуурлын шугам 2010 оны тогтмол үнээр тооцогдон 2300 юань болж, хөдөөгийн ядуу хүн амын тоо 166 сая болсон. Ядуурлыг бууруулах шинэ төлөвлөгөөний гол зорилго бол 2020 он гэхэд 2300 юаниар хэмжигдэх ядуурлын шугамнаас доош байгаа бүх ядуу хүнийг ядуурлаас гаргах, ядуу ба ядуу бус бүс нутгийн эдийн засаг болон нийгмийн хөгжлийн ялгааг багасгахад чиглэх юм. Хятад улс 14 ядуу бүс нутагт 832 ядуу дүүрэг, сум байгаа бөгөөд нийт 128000 ядуу тосгон, гацаа засгийн газрын дэмжлэгийг авах тооцоолол гаргасан байгаа.

2013 оны 11 дүгээр сард Ши Жинпин дарга “нарийн тогтоож ядуурлыг устгах” стратегийг танилцуулсан. Энэхүү стратегийг хэрэгжүүлэхийн тулд 2016 онд XIII таван жилийн ядуурлыг бууруулах төлөвлөгөөг гаргасан. Уг төлөвлөгөөнд: ядуу өрхүүдийг ХАА, аж үйлдвэрийн хөгжлөөр дэмжих (1), алслагдмал болон байгалийн хүнд нөхцөлд амьдарч буй 10 сая хөдөөгийн ядуу иргэдийг нүүлгэн шилжүүлж, тухтай орчин дахь амьдралын түвшинг сайжруулах – засгийн газар болон төрийн өмчит банкууд 5 жилийн хугацаанд 600 тэрбум юанийг нүүлгэн шилжүүлэх хуваарилахаар хүлээгдэж байгаа (2), ХАА болон экологийн нөхөн олговроор ядуу өрхүүдийн орлогыг дэмжих (3), ядуу өрхийн боловсролыг дээшлүүлэх (4), ядуу өрхүүдэд нийгмийн хамгааллын үйлчилгээгээр туслах – хамгийн бага амьжиргааны тэтгэмжийг өсгөх, хөдөөгийн хоршооллын эрүүл мэндийн үйлчилгээнд шинэчлэл хийж, ядуучуудын эрүүл мэндийн суурь үйлчилгээг хялбар байлгах (5) гэх зэрэг таван хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаагийн эхний үр дүн гараад эхэлсэн бөгөөд 2010 оны ядуурлын шугамны шинэчилсэн үнэлгээний дагуу хөдөөгийн ядуу хүн амын тоо 2010 онд 166 сая байсан бол 2016 онд 43 сая болж, улмаар жилийн ядуурлын түвшин 20 хувь болжээ.

Хятадын хөдөөгийн ядуурлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэхэд 1986 онд баталж, түүнээс хойш баримталж буй зохион байгуулалтын бүтцийн үзүүлэх нөлөө их, өөрөөр хэлбэл, хөдөөгийн ядуурлыг бууруулах үйл ажиллагааг удирдах бүлэг газарзүйн байршлаар бүх түвшинд тууштай ажиллаж байгаа юм.

Хятадын хөдөөгийн ядуурлыг бууруулах зохион байгуулалтын бүтэц



Эх сурвалж: Wang Sangui, Li Zhou and Ren Yanshun A case study from Reducing Poverty, Sustaining Growth, 2004

Хятадын хөдөөгийн ядуурлыг бууруулах үйл ажиллагааг удирдах бүлэг Төрийн зөвлөлийн дэргэд ажилладаг. Чиг үүргийнхээ дагуу Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо (ҮХШХ, түүний байршлаар захиран удирдах шат шатны байгууллага), Сангийн яам, түүний муж, орон нутаг дахь нэгжүүд, Хятадын Хөдөө аж ахуйн банк (ХХААБ), түүний салбар нэгжүүд болон бусад яамдууд харилцан хамтран ажиллана. Хөгжлийн санхүүжилтийн схем чухал учраас хошуу, тосгон, өрхүүдэд чиглэсэн олон төрлийн төсөл хөтөлбөр хэрэгжихдээ ХХААБ-ны салбаруудаар дамжин хэрэгжинэ. Иймээс хошууны захиргаа, тосгоны зөвлөлийн удирдлагууд ХХААБ-ны салбар нэгжтэй нягт хамтын ажиллагаатай байгаа нь ядуурлаас ангижруулахад оролцогч бүх талуудын үндсэн даалгавар, гүйцэтгэх шат дамжлага, хариуцлага хөтөлбөрөөс хөтөлбөрт илүү шинэчлэгдэн сайжирсаар байгаа дүр зураг харагдаж байгаа юм. ЯБУБ бол өдөр тутмын үйл ажиллагаатай, Хятадын хөдөөгийн ядуу бүсэд судалгаа, шинжилгээ явуулж, засгийн газрын ядуурлыг бууруулах бодлогод нөлөө үзүүлж, бодлогын хэрэгжилтийг сайжруулах санал оруулах, хөнгөлөлттэй зээлийн схем, сангийн санхүүжилт, хуваарилалтын төлөвлөгөөг бэлтгэх, ядуурлаас ангижруулах хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тоо мэдээллийг цуглуулж, хуваарилалт, ашиглалт, зээлийн сангуудын эргэн төлөлтийн байдалд дүн шинжилгээ хийх үндсэн үүрэгтэй ажилладаг. Ядуу бүс нутгийн бүх түвшний засаг захиргааны нэгж нь энэхүү төв байгууллагын толь шиг ажиллаж байдаг. Ихэнх яамдууд, тэдгээрийн газар, хэлтэс үндэсний хэмжээн дэх ядуурлыг бууруулах системийн үйл ажиллагааны гол хэсэг болно. Тухайлбал, Боловсролын яам нь анхан шатны боловсролын төслүүдийг удирдаж ажиллах бөгөөд Эрүүл мэндийн яам нь ядуу бүс нутгийн эрүүл мэнд, эрүүл ахуйг сайжруулах чиг үүргийг хариуцан ажилладаг. Харин нам, засгийн газрын байгууллагууд болон том аж ахуйн нэгжүүд нь засгийн газрын үүрэг хариуцлагыг хуваалцахад оролцож, засгийн газраас санхүүжихээс гадна өөрсдийн ядуу бүс нутагт төрөл бүрийн төсөл хэрэгжүүлэх саналуудыг гаргаж байдаг.

ӨМӨЗО болон Гүйжөү мужийн хоёр байршилд хэрэгжиж буй ядуурлаас ангижруулах бодлого ба хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Хятад улс 2020 оны зорилгодоо хүрэхийн тулд 2010 оны ДНБ болон нэг хүнд ногдох орлогыг хоёр дахин өсгөх, эдийн засгийн өсөлтийн жилийн дундаж хувь 6.5 хувь байх, хот ба хөдөөгийн нэг хүн амд ногдох зарцуулагдах орлого жилд багадаа 5.8 хувиар нэмэгдэх шаардлагатай гэж үзэж байна. Хөгжлийн илүү бодитой хувилбар бол зарим бүс нутагт өсөлтийн хувь өндөр байхад зарим бүс нутагт бага байна гэж тодорхойлсон.

Хятадын төв болон баруун бүс нутгийн хувьд хуучны хувьсгалч суурьтай бүс нутаг, үндэсний цөөнхтэй бүс нутаг, хил орчмын бүс нутаг, илүү ядууралтай бүс нутаг, тухайлбал, ХАА-н үйлдвэрлэлийн бүс, үндсэн эко-системийн үйлчилгээний бүсэд үндэсний хүнсний аюулгүй байдал болон экологийн аюулгүй байдлыг хангах, янз бүрийн нийгмийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, амьжиргааны түвшинг ахиулах, төрийн үйлчилгээг сайжруулах тал дээр голлон анхаарал хандуулах болсон.

Эдийн засгийн өсөлтийн загвар болон эдийн засгийн бүтцийг тохируулж, өндөр чанарыг хадгалах хийгээд хөгжлийн үр дээшлүүлэхийн тулд тусгайлсан шаардлагыг гаргасан. Үүнд: хөрөнгө оруулалт үр ашигтай байх, бүтээгдэхүүн худалдаалагдаж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хангах, үйлдвэрүүд ашигтай байх, ажиллагсад хангалттай орлоготой, засгийн газар татвар цуглуулах ёстой гэжээ. Эдийн засгийн өсөлтийн загвар болон эдийн засгийн бүтцийг тохируулагч нь инноваци бөгөөд шинэ технологи, шинэ салбар, шинэ бизнесийг илүү дэмжих хандлагатай байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган болон Тонгляо аймаг, өмнөд хэсгийн Гүйжөү мужийн Аншун болон Хуйшуй шянь гэх зэрэг газрын ядуурлын шалтгаан нь байгаль орчин болон нийгэм-эдийн засгийн шинж байдалтай. Эдгээр бүс нутагт байгалийн тогтоц болон цаг ууртай холбоотойгоор ядууралд өртөж байгаа бол мөн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой хүн амын 2/3-оос илүү нь хүнд өвчин, түүний эмчилгээний зардалтай холбоотой шалтгаанаар ядуу болсон. Үүнээс гадна эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын харилцан адилгүй хөгжлийн улмаас орон нутагт дэд бүтэц, усан хангамж хүрэлцээгүйн улмаас ядууралд өртсөн.

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган болон Тонгляо аймаг, өмнөд хэсгийн Гүйжөү мужийн Аншун болон Хуйшуй шянь нь газарзүйн байршил, ХАА болон аж үйлдвэр эрхэлж буй байдал, цогц дэд бүтцийн сүлжээнд холбогдож буй байдал, соёл зан заншлаар ялгаатай ч үндэсний цөөнх талаасаа ижил төстэй. Ядуурлаас ангижруулах, ядуурлын тусламжийг хэмжих арга адилхан: илүү олон ажлын байраар хангагдах боломж, нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан ядуу өрхүүдийн тоо, ядуу хүмүүсийг эко ажлын байраар хангаж буй байдал, ядууралд өртсөн бүс нутгийн боловсролыг дээшлүүлэх байдал, нийгмийн хамгааллыг сайжруулж буй байдлыг хэмжиж байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган болон Тонгляо аймагт ядуу болон үхэр сүргийг үржүүлэн өсгөж байгаа бол өмнөд хэсгийн Гүйжөү мужийн Аншун болон Хуйшуй шяньд газар тариалан, байгалийн аялал жуулчлалын салбарт ажлын байрны боломж ихсэж байна. Эдгээр байршилд олон ядуу өрхүүд дэд бүтэц, орон сууц, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, үйлдвэрлэл-үйлчилгээний газар гэх мэт цогц байдлаар шийдвэрлэсэн

хот төлөвлөлттэй орон сууцны хороолол руу шилжин суурьшиж, хотын иргэншилтэй болж байна.

“Тосгон болгон иж бүрэн хөгжлийн замтай”, “айл өрх бүр орлогын тогтмол эх сурвалжтай”, “өрхийн гишүүн бүр хөдөлмөр эрхэлж, ажилтай” байна гэсэн амьдрах ухааны философи хүчтэй байна.

БНХАУ-ын ӨМӨЗО ба Гүйжөү мужийн ядуурлаас ангижруулах бодлогын хэрэгжилтийн өнөөгийн байдлын харьцуулалт

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган болон Тонгляо аймаг, өмнөд хэсгийн Гүйжөү мужийн Аншун болон Хуйшуй шянийн орлогын эх сурвалж нь МАА, газар тариалан, аялал жуулчлал юм. 2016 оноос хойш ядуу бүс нутгийн эдийн засгийн бүтцийг сайжруулах бодлогыг эрчимжүүлснээр эдийн засгийн төрөлжилт хурдацтай явагдахын сацуу шинэ салбар, шинэ зах зээл, шинэ бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ хүчтэй бэхжиж байна.

Тал хээрийн бүс нутагт мал аж ахуй зонхилсон туршлага давамгайлж, гол нь ХАА-н нийлүүлэлтийн сүлжээний талаарх бизнес загварыг туршин хөгжүүлж байна. Зөөлөн дулаан уур амьсгалтай, чийглэг газар хөрс, үндэс, гадаргын тогтцоос хамааран хөдөө аж ахуйн тариаланд орлуулах болон хослон тариалах бизнесийн сүлжээ идэвхжиж байгаа талтай. Эдгээрийн үр дүнд зам, ус гэх мэт инженерийн барилга, байгууламжид ядуу өрх, ядуу бүсийн гацаа тосгоны удирдлага, намын санаа зовних шаардлагагүй, энэ бол Хятадын Коммунист нам, засгийн газар, ЯБУБ-ын үндсэн үүрэг, хариуцлага бөгөөд харин орон сууц, боловсрол, эрүүл мэнд нь хувь хүн, өрх, ядуу бүсийн гацаа тосгоны удирдлага, намын ажилтнуудын хамтран шийдэх асуудал болж байна.

Өргөн дүр зургаар харвал, 2012 онд тодорхойлсон “Таван багц асуудлыг хамруулсан нэгдсэн төлөвлөгөө” болон “Дөрвөн хэсэгтэй цогц стратеги”-ийн хүрээнд тодорхойлсон арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна. Нарийвчлан авч үзвэл, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган болон Тонгляо аймаг, өмнөд хэсгийн Гүйжөү мужийн Аншун болон Хуйшуй шянь нь түүхэн хөгжлийн энэ цагт ядуурлыг урд хожид байснаас ч илүү хэмжээгээр бууруулж, ядуурлаас ангижирч буй жишээ баримт, тоо мэдээлэл, баталгаа нотолгоог бодит байдалд үзүүлж байна. Үүний нэг тод жишээ бол ядуурлаас ангижруулсан өрхийн тоог мэдээлж буй байдал юм.

Эдгээр бүс нутагт зорилтот ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлж, дэд бүтэц болон усан хангамжийг хүртээмжийг дээшлүүлснээс гадна нүүлгэн шилжүүлэлтийн төсөл хэрэгжүүлснээр ядуу өрхүүд орчин үеийн хотын хороолол руу шилжин амьдрах болсон. Ийм зорилтот ядуурлыг бууруулах бодлогод дээрх бүс нутгийн үндэсний цөөнх илүү хамрагдаж байна. Тэдний соёлыг орчин үеийн мэдээлэл, технологи, инновацийн ололт, дэвшлээр баяжуулан Хятадын онцлогтой соёлын хөгжилд мэдэгдэхүйц үр нөлөө үзүүлж байна.

Ядуу бүс нутгийн өвөрмөц байдал, онцлог, ахуй соёлд нийцүүлэн ядуурлыг бууруулах зорилгыг ялгаатай тодорхойлжээ. Энэ нөхцөлд ядуу бүсийн хүн амын хүнсний аюулгүй байдал, хувцас, орон байрны эрэлт хэрэгцээ, эрүүл мэнд болон боловсролын үйлчилгээний хүртээмжийг нарийвчлан тодорхойлж, бичил, жижиг, дунд бизнесийн

орлогын өсөлтийг үндэсний дундаж руу дөхүүлэх байдал гэх зэрэг орон нутгийн хөгжлийн суурь хэрэгцээнд голлон анхаарал хандуулж байна.

Ядууралд өртсөн бүс нутгийн хүн амыг ядуурлын шинж байдлын дагуу бүртгэж, бүртгэлийн системийг хэрэгжүүлэх хөтөлбөртэй уялдуулж өгсөн.

Таван багц бодлогын дагуу аж үйлдвэрийн хөгжил, нүүлгэн шилжүүлэлт, эко-нөхөн олговор, нийгмийн хамгааллын асуудлыг шат дараатай шийдвэрлэж байна.

Орон нутгийн ядуурлын шалтгааныг ядуу хүмүүс болон орон нутгийн засаг захиргааны хүмүүстэй хамтран тодорхойлж, ядуурлаас ангижруулах төлөвлөгөөг хамтран боловсруулан, техник туслалцааны хөрөнгийг уялдуулан хуваарилсан. Тиймээс 128 000 тосгоны баг үүсэж, 540 000 намын ажилтнууд нь тосгон бүрт дунджаар 3 ажилтан удирдан зохион байгуулж, эдгээр хүмүүс нэг тосгонд дунджаар 2-3 ажиллаж байна.

ӨМӨЗО болон Гүйжөү мужийн хоёр байршилд ядуурлаас ангижруулах бодлогын хэрэгжилтийн үр дүн

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган болон Тонгляо аймаг, өмнөд хэсгийн Гүйжөү мужийн Аншун болон Хуйшуй шянь гэх зэрэг газарт “Таван хүрээтэй багц бодлого” буюу эдийн засаг, улс төр, соёл, нийгэм, экологийн үйлчилгээ нь ядуурлыг бууруулах, ядуурлаас ангижруулах гол чиглэл болсон.

“”Дөрвөн хэсэгтэй цогц стратеги”-ийн хүрээнд нийгмийн бүх давхарга хөгжил цэцэглэлтэд хүрэх, шинэчлэлийг гүнзгийрүүлэх, хуульд суурилсан засаглалыг илүү хөгжүүлэх, намын засаглал өөрөө бэхжих үйл явц хүрээгээ тэлж байна.

Ийнхүү намын манлайлал болон засгийн газрын удирдлага, зохион байгуулалтын үр дүнд:

1. Ядуурлаас ангижруулах зорилтот бүлгийн стратеги тодорхой болсон.
2. Санхүүгийн хөрөнгө оруулалт нэмэгдсэн.
3. Ядуу хүмүүсийн амьдралын ухаан тэлсэн.
4. Ядуурлыг бууруулах нийгмийн хүч шинэчлэгдсэн.
5. Ядуурлын үнэлгээ, хяналт шинжилгээ эрс сайжирчээ.

Үндсэндээ ядуурлаас ангижруулах хүчин чармайлт нь хөшүүрэг, цар хүрээ, үр нөлөөгөөрөө харилцан параллель байж чадахгүй, иймд соёлын хүчин зүйлийг хүчтэй тулгуур болгож байна.

2017 оны эцэст, нийт ядууралд өртсөн хүн амын тоо 30.46 сая болж, 66 саяас илүү хүн амыг таван жилийн хугацаанд ядуурлаас гаргажээ. Ядуурлын шугамнаас доогуур амьдарч байгаа ядуу хүмүүсийн тоо 2/3-аар багассан. 2016 онд 28 ядуу газар ядуурлаас ангижирч байсан бол 2017 онд 100 газар ядуурлаас ангижраад байна.

Цаашид аж үйлдвэрт суурилан ядуурлаас ангижруулах бодлогыг эрчимжүүлэх хандлагатай. Ядуурлыг бууруулах шинэ шинэ арга хэлбэрийг олж байна. Үүнд: аялал жуулчлалд тулгуурлах, онлайн худалдааг ашиглах, нүүлгэн шилжүүлэлтийг

үргэлжлүүлэх гэх зэргээр орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих чиглэлтэй байна.

Байгаль орчны хувьд ойжуулах хөтөлбөрийг түлхүү дэмжихэд анхаарал хандуулж байгаа. Энэ нь ядуу бүс нутгийн эко орчны тэнцвэрт байдлыг тогтвортой хадгалах үр нөлөө үзүүлэх юм.

Ядуу бүс нутгийн дэд бүтцийн барилгажилтад ихээхэн хөрөнгө оруулалт хийж, нийгмийн үйлчилгээний хөгжлийн түвшинг ахиулна.

Ядуурлаас ангижруулах бодлогын институцийн тогтолцоо

БНХАУ-ын Засгийн газар зорилтот ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэхдээ институцийн долоон системийг тодорхойлсон: бүртгэлийн систем, бодлогын систем, хөрөнгө оруулалтын систем, туслалцааны систем, нийгмийн дэвшлийн систем, олон сувагтай, олон чиглэлтэй удирдлагын систем, үнэлгээний систем.

Бүртгэлийн системтэй болсноор ядуу бүсийн орон нутгийн засаг захиргаанаас хэрэгжүүлэх тусгай, онцлог төсөл хөтөлбөрүүд тодорхой болж, ажил үүргийн хариуцлагын түвшин ахисан.

Дээрээс доошлох бодлогын тогтолцоотой. Ядуу бүс нутаг болон ядуурлаас ангижруулах ялгаатай бодлого хэрэгжүүлнэ. Засаг захиргааны бүх түвшинд XIII таван жилийн хугацаанд (2016-2020) ядуурлыг бууруулахтай холбоотойгоор нийтдээ 118 бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж байгаа. Эдгээр бодлогын баримт бичиг нь аж үйлдвэрийн хөгжил, нүүлгэн шилжүүлж дахин байршуулах, ажиллах хүчний экспорт, тээвэр, ус хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн сайжралт, санхүүгийн хөгжил, өмхөрсөн барилгуудыг засварлан сэргээх, газрын ашиглалтын өсөлт/бууралт, хөрөнгийн орлого гэх мэт томоохон, хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглэж байна.

Хөрөнгө оруулалтын систем нь санхүүгийн болон хүний нөөцийн хөрөнгө оруулалтыг баталгаажуулна. Төв засгийн газар ядууралтай тэмцэх ажлыг зохион байгуулахдаа хангалттай хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй гэж үзэж байна. Тиймээс 2016 онд ядуурлыг бууруулах санд 100 тэрбум юанийн санхүүжилтийг төвлөрүүлснээс 66.7 тэрбум юань нь төв засгийн газраас, 49.3 тэрбум юанийг орон нутгийн засаг захиргаанаас татсан. Засгийн газар жил тутам энэхүү санг 43.4 хувиар өсгөх бөгөөд орон нутгийн засаг захиргааны санхүүжилтийг 56.1 хувиар өсгөх зорилготой байгаа. Орон нутгийн засаг захиргаа 60 тэрбум юанийн зээлийг үйлдвэрлэл, ядуу бүс нутгийн амьдралын нөхцөлийг сайжруулахад зарцуулах юм. XIII таван жилийн хугацаанд Хятадын засгийн газар ойролцоогоор 250 тэрбум юанийг орон нутгийн хөрөнгө оруулалтад төлөвлөж, ядуурлыг бууруулах зорилттой. Санхүүгийн институциуд мөн оролцож, тухайлбал, 72.6 тэрбум юанийн санхүүгийн бондыг нүүлгэн шилжүүлж, дахин байршуулахаар гаргаж, нийтдээ таван жилийн хугацаанд 350 тэрбум юанийн хөрөнгө оруулалтыг татахаар хүлээгдэж байна. Нэмэлт 170.6 тэрбум юанийн бичил зээл хэлэлцэгдэж, нийт дүнгээрээ 283.3 тэрбум юанийг 8.02 сая ядуу өрхөд санал болгоод хэрэгжүүлээд байгаа юм. Үүний үр дүнд ядуу өрхүүдийн зээл ашиглах хувь хэмжээ 2 хувь байсан нь 2014 онд 26.7 хувь болж өссөн.

Туслалцааны системийн хүрээнд намын ажилтнууд тосгонд ажиллана. 1-3 жилийн хугацаатайгаар нийтдээ 775000 хүн тосгонд ажиллаж, ядуу өрхүүдэд тусална.

Нийгмийн дэвшлийн систем Хятадын зүүн болон баруун бүс нутгийг холбож, ядуурлыг бууруулах асуудлаар хамтран ажиллах тухай заавар зөвлөмжийг Засгийн газраас гаргасан байгаа. Нийтдээ 30 тусгаар тогтносон муж, аймгийг Бээжин, Тяньжин, Хэбэйтэй холбон Бээжин-Тяньжин-Хэбэй гэсэн эдийн засгийн бүсийг хөгжүүлэн зүүн талаас хөгжсөн 267 газрыг баруун талын ядуу 592 газартай “тогтмол хэмжээтэй” туслалцааны хөтөлбөр хэрэгжүүлнэ. Нийт дүнгээрээ 2000 гаруй ядуу тосгон тусламж, туслалцааг хүлээн авах юм. Ерөнхийдөө Төрийн өмчит хөрөнгийн удирдлага захиргааны зөвлөлөөс⁴ төрийн өмчит компаниудыг ядуу бүс нутгийн аж үйлдвэрт хөрөнгө оруулах сан байгуулан 100 муж, аймгийн 10000 тосгон, гацаанд ядуурлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Бүх Хятадын үйлдвэр, худалдааны нийгэмлэгээс 22000 аж ахуйн нэгжийг энэхүү компанид ажилд татан оролцуулж, “10000 аж ахуйн нэгж 10000 тосгонд” гэсэн ядуурлыг бууруулах үйл ажиллагааг өрнүүлсэн.

Олон чиглэлтэй удирдлагын системд засгийн газар ядуурлыг бууруулах ажлын хэрэгжилтийн хэмжүүрийг оруулан хөгжлийн стратеги, бодлогын хэрэгжилтийг хянан ажиллаж байна. “12317” ядуурлыг бууруулах суваг ажиллаж, хяналт ба удирдлага, аудит ба санхүү, мэдээлэл ба нийгмийн хүч, эдгээрийг үнэлэх экспертийн багийг ажиллуулж байна.

Үнэлгээний системийн дагуу 2016-2020 он хүртэл ЯБУБ-ийн зөвлөл жил тутам үнэлгээ хийнэ. Үнэлгээ нь ядуурлын бууралтын нөлөө, ядуурлын шалтгааныг илүү нягт тодорхойлох байдал, зорилтот дэмжлэг туслалцаа, ядуурлыг бууруулах сангийн хэрэглээ ба менежмент, ядуурлыг бууруулах хүчин чармайлт, ядуурлаас ангижруулах үйл ажиллагааг таниулах байдал гэх зэрэгт төвлөрч байна. 2016 онд 22 төв болон баруун хэсгийн муж, бие даасан орон, аймгуудад ядуурлыг бууруулах үйл ажиллагааг эцэслэн боловсруулсан бөгөөд үүний дагуу муж хоорондын ядуурлыг үнэлж, гурав дахь талын үнэлгээг давхар хийлгэн ядуурлын мониторингийн тоо мэдээлэл, бүртгэлийн тоо мэдээлэл, гүйцэтгэлийн үнэлгээ, ядуурлыг бууруулах тусгай сангуудын хэрэглээ, менежментийн асуудлаарх аудит, удирдлага зохион байгуулалтыг нэгтгэж чадсан.

Ядуурлаас ангижруулах бодлогын хэрэгжилтийн үр нөлөө, суралцах туршлагаас

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган болон Тонгляо аймаг, өмнөд хэсгийн Гүйжөү мужийн Аншун болон Хуйшуй шянь тус бүрт 2016 оноос хойш ядуурлыг бууруулах үйл ажиллагаа эрчимжсэн.

1978 оны шинэчлэлийн суурь 2013 онд баяжигдан шинэчлэгдэж, ядуурлыг бууруулах асуудлын хүрээнд БНХАУ шинэчлэлээс шинэчлэл рүү явж байна. 40 гаруй жилийн хугацаан дахь ядуурлыг бууруулж буй хөгжлийн стратеги, бодлого зөвхөн Хятад улсад төдийгүй дэлхийн улс орнууд болон олон улсын байгууллагуудад жишээ туршлага болж байна.

⁴ State-owned Assets Supervision and Administration Commission of the State Council (SASAC)

Гол нь ядуурлыг бууруулах стратеги, бодлого тасралтгүй, тууштай явагдаж, төрийн бодлогын залгамж чанарыг батжуулж байгаа нь төрийн бодлогын үнэлгээ талаас авч үзвэл бодлогын хэрэгслийн сонголт, бодлогын төлөвлөлт ба хэрэгжилт, бодлогын хэрэгжүүлэх хяналтын бүтэц, институцийн тогтолцоонд сул тал, ан цав бага байсан.

БНХАУ-ын Коммунист нам болон засгийн газрын манлайлал хүчтэй байна. Засгийн газар ба зах зээлийн институцийн тогтолцоо улс орон бүрт ялгаатай болохоор засгийн газар, эсвэл зах зээл манлайлах нь хөгжлийн замаас ихээхэн хамаарах талтай. Аль алинд нь давуу тал ч байна, мөн сул тал ч байна. Гол нь улс орны хөгжил цэцэглэлт, дэлхийн зах зээлд эзлэх байр суурь, хүн амын амьжиргааны дээшлэлт нь хөгжлийн гол утга болох билээ.

Ядуурлыг бууруулах нь ядуу хүмүүс болон оролцогч бүх талуудын хамтын ажиллагаанаас шалтгаална. Ядуурлыг шинж байдлыг нарийвчлан тогтоож, түүний үндсэн дээр ялгаатай бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль, нийгэм, эдийн засаг гэсэн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаас гадна өөрийн орны онцлогтойгоор улс төр, соёлыг онцолж байгаагаас харвал улс орнууд өөрийн орны хөгжлийн зам, ядууралтай бүс нутаг, ядуу өрхүүдэд ялгаатай бодлого хэрэгжүүлэх боломж нээлттэй.

БНХАУ-ын засгийн газар нь БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган болон Тонгляо аймаг, өмнөд хэсгийн Гүйжөү мужийн Аншун болон Хуйшуй шяньд зам ба ус хамгааллын талаарх улс төр, макро эдийн засгийн бодлогын шийдлийг орон сууц, боловсрол, эрүүл мэнд гэсэн нийгмийн бодлоготой хослуулж, аж үйлдвэр, мэдээлэл, инновацийн бодлогоор орон нутгийн хөгжлийг дэмжин Хятадын онцлогтой соёлд төвлөрөн ядуу бүс нутаг, ядуу өрхүүдийг ядуурлаас гаргаж байна.

Ашигласан материал

- Goh, Chor-ching; Xubei Luo; Nong Zhu (September 2009). "Income growth, inequality and poverty reduction: A case study of eight provinces in China". *China Economic Review*. 20 (3): 485–496.
- Jian, Tianlun; Jeffrey D. Sachs; Andrew M. Warner (1996). "Trends in regional inequality in China". *China Economic Review*. 7 (1): 1–21
- Liu Cui (2011) "The impact of china's gansu and inner mongolia poverty reduction project on net rural income per capita growth". Master thesis, University of California, San Diego
- Nogendra Sapkota, Sangui Wang, and Guobao Wu (2017) "Poverty reduction and development national strategies and a case study of adb-funded pilot project in Nayong county in Guizhou province, people's republic of china". ADB East Asia Working Paper Series Park, A. Wang, S. (2001) "China's poverty statistics". *China Economic Review* 12 (2001) 384–398
- Weiss John, (2003) "Explaining Trends in Regional Poverty in People's Republic of China". ADB Institute Discussion Paper No1.
- Wu, J. P. (2005). *China's Income Distribution, 1985-2001*. *The Review of Economics and Statistics*, 87, 763-775.
- Yang, Dennis Tao (1999-05-01). "Urban-Biased Policies and Rising Income Inequality in China". *The American Economic Review*. 89 (2): 306–310.

- Yuan Zhang (2016) “Urbanization, Inequality, and Poverty in the People’s Republic of China”. ADBI Working Paper Series
- Secure a Decisive Victory in Building a Moderately Prosperous Society in All Respects and Strive for the Great Success of Socialism with Chinese Characteristics for a New Era Delivered at the 19th National Congress of the Communist Party of China October 18, 2017 Xi Jinping
- Chinese Approach to the Eradication of Poverty: Taking Targeted Measures to Lift People out of Poverty a Speech at the Expert Panel on the Implementation of the Third UN Decade for the Eradication of Poverty (2018-2027) Tan Weiping, Deputy Director-General, IPRCC (Addis Ababa, April 18, 2018)
- Wang Sangui, Li Zhou and Ren Yanshun A case study from Reducing Poverty, Sustaining Growth, 2004
- Xi Jinping Up and out of poverty, 2018. P.167-223
- Xi Jinping, The Governance of China I, 2018. 3-266
- Xi Jinping, The Governance of China II, p.3-414
- Zhong, Hai (March 2011). "The impact of population aging on income inequality in developing countries: Evidence from rural China". China Economic Review. 22 (1): 98–107.
<https://web.archive.org/web/20110716071749/http://hdrstats.undp.org/en/indicators/103.html>
- *"Overview". Worldbank.org. Retrieved December 28, 2017.*
- *"Latest data reveal how far away China is from the 2020 poverty elimination goal". news.cgtn.com. Retrieved June 1, 2019.*
- <http://isdpeu/publication/chinas-anti-poverty-efforts-problems-and-progress/>
- <https://geopoliticalfutures.com/china-is-still-really-poor/>
- https://www.researchgate.net/publication/262188483_Poverty_Alleviation_in_China_A_Lesson_for_the_Developing_World